

Зааварт нэмэлт
оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын 2015 оны А/72 дугаар тушаалаар баталсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-т дор дурдсан агуулгатай 4.1.3, 4.1.4 дэх заалтыг тус тус нэмсүгэй.

“4.1.3.Галт зэвсгийн сургалтанд хамрагдсаныг нотлох бичиг баримт /диплом, гэрчилгээ, үнэмлэх зэрэг/-тай дараах иргэдийг галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтаас чөлөөлж, сургалтын гэрчилгээг олгож болно:

а/буудлага спортын тамирчин, багш дасгалжуулагч;

б/ цэрэг, цагдаагийн сургууль /галын бэлтгэлд хамрагдсан/ төгссөн иргэн;

в/зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, тагнуул, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тусгай албадын алба хаагч;

г/Галт зэвсгийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдөр буюу 2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө гэрээт, харуул хамгаалалтын сургалтад хамрагдсан иргэн.

4.1.4.Сургалтаас чөлөөлөгдөж сургалтын гэрчилгээ авах иргэн “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” Сангийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны 14/10 дугаар тушаалд заасан тарифын дагуу гэрчилгээний үнийг төлнө.”

2.Тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /тэргүүн дэд комиссар Ц.Батсүх/-д үүрэг болгосугай.

3.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Р.ЧИНГИС